



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар Б/28

Хэрлэн сум

Н.Зоригтбаатарт буцалтгүй  
тусламж олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Насанжаргалын Зоригтбаатарын гаргасан өргөдлийн дагуу нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор 300,000 (гурван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн (С.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР